

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДОА-2023/03/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Чойбалсан хот
2024 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор: Б.Болортуул
Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn
Аудитын менежер: И.Сэмжидмаа
Утас: 7058-4204, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Нармандах
Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakh@audit.gov.mn
Аудитор: Б.Одхүү
Утас: 7058-4207, Цахим хаяг: odkuu@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	9
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	9
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	9
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	10
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	Error! Bookmark not defined.
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	Error! Bookmark not defined.
4.1 Ерөнхий зүйл.....	15
4.2 Материаллаг байдал.....	15
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	7
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	88

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2024.03.25 № 331

танай _____-ны № _____-т

ЦАГААН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГА
Д.БАТМАГНАЙ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Цагаан-Овоо сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цагаан-Овоо сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Өмнөх аудитаар өгсөн алдаа зөрчлийг давтан гаргасан байна.

Аудитын гол асуудал

Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх 2023 оны хөгжлийн төлөвлөгөөний биелэлтийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 02 дугаар тогтоолоор "хангалттай" гэж дүгнэсэн нь бодитой биш байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хангалттай зохистой гэж үзлээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

011021226

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,134,499.1	986,480.1
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	690,372.2	402,374.8
33	АВЛАГА	242,652.1	379,646.7
35	БАРАА МАТЕРИАЛ	201,474.9	204,458.5
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,567,592.4	4,718,358.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,567,592.4	4,718,358.0
39200	Биет хөрөнгө	3,348,671.9	4,122,231.0
39300	Биет бус хөрөнгө	218,920.5	596,127.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,702,091.6	5,704,838.1
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,173.3	0.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,173.3	0.0
41300	Өглөг	1,173.3	0.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,700,918.3	5,704,838.1
51	Засгийн газрын хувь оролцоо	4,700,918.3	5,704,838.1
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,603,781.3	1,981,479.3
51200	Хуримтлагдсан үр дүн	2,760,857.9	3,387,079.7
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	336,279.0	336,279.0
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,702,091.6	5,704,838.1

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	5,127,268.4	4,545,689.1
11	ТАТВАРЫН ОРЛОГО	1,150,331.4	2,393,711.6
110	Орлогын албан татвар	447,184.7	1,388,628.8
1100	Хувь хүний орлогын албан татвар	467,091.8	1,408,517.9
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-19,907.2	-19,889.0
113	Хөрөнгийн албан татвар	271,256.5	612,353.5
118	Бусад татвар, төлбөр, хураамж	431,890.3	392,729.3
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,596,056.9	1,306,879.6
120	Нийтлэг татварын бус орлого	1,356,056.9	866,879.6
122	Тусламжийн орлого	240,000.0	440,000.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,380,880.1	845,097.8
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,995,019.3	2,635,648.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,995,019.3	2,635,648.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,426,694.6	2,231,363.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	406,684.8	618,464.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,355.2	76,233.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	153,606.6	74,619.8
2104	Хангамж, бараа материалын зардал	93,537.8	104,141.3
2105	Нормативт зардал	2,500.0	699.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,294.2	25,942.4
2107	Томилолт, зочны зардал	10,797.0	12,464.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,308.8	508,118.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	682,610.2	810,681.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,568,324.7	404,285.1
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	2,132,249.1	1,910,040.2
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	4,860,525.1	1,283,818.4
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-2,728,276.0	626,221.8

Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,558,378.3	0.0	7,558,378.3
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-129,184.0	0.0	-129,184.0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,429,194.3	0.0	7,429,194.3
9	Тайлант үеийн үр дүн	-2,728,276.0	0.0	-2,728,276.0
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,700,918.3	0.0	4,700,918.3
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	4,700,918.3	0.0	4,700,918.3
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.0	0.0	0.0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,700,918.3	0.0	4,700,918.3
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0	0.0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	377,698.0	0.0	377,698.0
19	Тайлант үеийн үр дүн	626,221.8	0.0	626,221.8
20	2023 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл	5,704,838.1	0.0	5,704,838.1

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,895,861.0	3,895,555.7
11	ТАТВАРЫН ОРЛОГО	1,150,331.4	2,393,711.6
110	Орлогын албан татвар	447,184.7	1,388,628.8
1100	Хувь хүний орлогын албан татвар	467,091.8	1,408,517.9
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-19,907.2	-19,889.0
113	Хөрөнгийн албан татвар	271,256.5	612,353.5
118	Бусад татвар, төлбөр, хураамж	431,890.3	392,729.3
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	5,484.0	13,952.5
1181	Газрын төлбөр	421,819.8	372,343.8
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	4,586.5	6,433.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	364,649.5	656,746.2
120	Нийтлэг татварын бус орлого	124,649.5	216,746.2
122	Тусламжийн орлого	240,000.0	440,000.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,380,880.1	845,097.8
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,648,018.9	2,220,382.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,648,018.9	2,220,382.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,079,694.2	1,816,097.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	406,386.7	618,464.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,355.2	76,233.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	160,817.6	74,619.8
2104	Хангамж, бараа материалын зардал	66,406.1	66,508.0
2105	Нормативт зардал	2,500.0	699.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	37,092.4	30,345.0
2107	Томилолт, зочны зардал	10,797.0	12,464.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,778.2	511,151.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	322,560.9	425,612.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,568,324.7	404,285.1
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,247,842.1	1,675,173.0
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	1,036,377.0	1,793,170.3
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,036,377.0	1,793,170.3
2200	Дотоод эх үүсвэрээр	1,036,377.0	1,793,170.3
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-1,036,377.0	-1,793,170.3
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-130,000.0	-170,000.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	130,000.0	170,000.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	81,465.2	-287,997.3
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	608,907.0	690,372.2
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	690,372.2	402,374.8

Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,289,139.8	3,850,047.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,039,328.5	1,888,627.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,634,829.2	1,484,342.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	590,012.2	575,941.5
210101	Үндсэн цалин	548,514.5	402,555.5
210102	Нэмэгдэл	0	128,926.9
210104	Урамшуулал	41,497.5	44,459.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	72,664.2	71,084.4
210201	Тэтгэврийн даатгал	49,783.2	48,819.9
210202	Тэтгэмжийн даатгал	5,857.3	5,659.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,695.5	4,466.9
210204	Ажилгүйдлийн даатгал	915.1	960.6
210205	Эрүүл мэндийн даатгал	11,413.1	11,177.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	589,976.5	569,143.8
210301	Гэрэл, цахилгаан	51,967.5	34,003.7
210302	Түлш, халаалт	536,450.8	534,595.1
210303	Цэвэр, бохир ус	1,558.2	545.0
2104	Хангамж, бараа материалын зардал	50,073.4	45,571.4
210401	Бичиг хэрэг	15,955.9	14,293.3
210402	Тээвэр, шатахуун	18,317.5	16,855.5
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,000.0	1,945.8
210404	Ном, хэвлэл	2,200.0	1,276.9
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	600.0	600.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,000.0	10,600.0
2105	Нормативт зардал	700.0	699.8
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	700.0	699.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	39,437.8	38,876.8
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,656.0	3,655.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,000.0	1,440.0
210604	Урсгал засвар	33,781.8	33,781.8
2107	Томилолт, зочны зардал	14,132.0	12,464.0
210702	Дотоод албан томилолт	14,132.0	12,464.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,700.0	9,845.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	12,600.0	8,068.2
210803	Даатгалын үйлчилгээ	550.0	257.7
210804	Тээврийн хэрэгслийн татвар	700.0	409.8
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	350.0	110.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	500.0	0.0
210807	Газрын төлбөр	1,000.0	1,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	262,133.3	160,714.5
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	260,133.3	160,714.5
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,000.0	0.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	404,499.3	404,285.1
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	400,285.1	400,285.1
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	400,285.1	400,285.1
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,214.2	4,000.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	2,214.2	2,000.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000.0	2,000.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,999,811.3	1,791,420.3
223001	Бусад хөрөнгө	1,999,811.3	1,791,420.3
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	250,000.0	170,000.0
230001	Эргэж төлөгдөх зээл	250,000.0	170,000.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,289,139.8	3,726,167.2
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,110,479.8	2,878,677.5
320001	Орон нутгийн төсвөөс	2,437,982.0	2,240,454.5
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	672,497.8	638,223.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Ү зүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	206,874.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	206,874.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	206,874.9
2104	Хангамж, бараа материалын зардал	3,331.2
210402	Тээвэр, шатахуун	3,331.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	203,543.7
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	203,543.7
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	206,874.9
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	206,874.9
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	206,874.9

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 153.4 сая төгрөгийн 4 зөрчил¹ илэрсэн зөрчилд 2 албан шаардлага, 2 зөвлөмж өгсөн.

5.1 Албан шаардлага

- ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр "Мод үржүүлгийн талбай байгуулах, тохижуулах" 20.0 сая, "Баянгол адгийн гарам" 15.0 сая, "Угааврын ваань /худаг/ Гүнцэнгэлэг" 20.0 сая төгрөгийн ажил хэрэгжээгүй, Аймгийн ОНХС-гаас олгох 34.2 сая төгрөгийн шилжүүлэг дутуу ирснээс "Гүнцэнгэлэг нуурын эко систем хамгаалах, тохижуулах" 63.3 сая төгрөгийн ажил 50.0 хувь, малын хөлийн татварын орлого 12 сард бүрэн төвлөрснөөс "Малын ашиг шим дээшлүүлэх /хөдөө аж ахуйн зориулалттай байгууламж ариутгах/" 8.7 сая төгрөгийн ажил дутуу буюу 50 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2-т "Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ", 41.2.7-д "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах" гэсэн заалттай нийцэхгүй байна.
- ХХС-ын зээл, зээлийн хүүгийн 8 иргэний 26.4 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн авлагатай байна. Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан "Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих, журам"-ын 4.7 -д "Иргэн, хуулийн этгээд авсан зээл, зээлийн хүүг гэрээнд заасан хугацаанд сангийн дансанд буцаан төлнө", 5.2-т "Сангийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг сумын Засаг дарга хариуцан арилгана" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

- 1.Төсвийн захирагчийн хүрэх үр дүнтэй холбоотой асуудал

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Илрүүлэлт

Цагаан-Овоо сумын 2023 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөг 4 зорилтын хүрээнд 22 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12-р сарын 18-ны өдрийн 17/02 дугаар тогтоолоор 94 хувиар үнэлсэн байна.

Үнэлгээнээс түүвэрлэн үзэхэд булгийн эх хашаалах 47.0 сая төгрөгийн ажил хийгдээгүй байхад тус ажлыг 100 хувь гэж үнэлсэн байгаа нь үнэлгээг бодитой хийгээгүй байна.

Цагаан-Овоо сумын иргэдийн Төлөөлөгчдийн хуралд өгсөн зөвлөмж: Сумын хөгжлийн төлөвлөгөөг үнэн бодитой үнэлж, дүгнэх.

2. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал.

Илрүүлэлт

Шилэн дансны цахим хуудсанд нийт 132 мэдээлэл оруулахаас худалдан авах ажиллагааны тайлан, санхүүгийн хагас жилийн тайлан, таван сая дээш орлогын мэдээ гэсэн 14 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн байна. Гүйцэтгэл 88.3 хувьтай байна.

Зөвлөмж: Шилэн дансны цахим хуудсанд худалдан авах ажиллагааны тайлан, санхүүгийн хагас жилийн тайлан, таван сая дээш орлогын мэдээг шилэн дансны хуульд заасан хугацаанд байршуулж байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор Төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” заалтыг хэрэгжүүлж ажиллах. Зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хүрэх үр дүнг ханган ажиллаагүй	1	127.0	-	-	1	127.0	-	-
ХХС-гийн хугацаа хэтэрсэн авлага	1	26.4	-	-	1	26.4	-	-
Нийт дүн	2	153.4	-	-	2	153.4	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
ХАА-ны тайлан, санхүүгийн хагас жилийн тайлан, таван сая дээш орлогын 14	1	0	-	-	-	-	1	0

**Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн								
Дүн	1	0	-	-	-	-	1	0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Сумын 2023 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөг ИТХ- ын 2023 оны 12-р сарын 18-ны өдрийн 17/02 дугаар тогтоолоор 94 хувиар үнэлсэн нь бодитой биш байна.	1	0	-	-	-	-	1	0
	1	0	-	-	-	-	1	0
Дүн	2	0	-	-	-	-	2	0
Нийт дүн	2	0	-	--	-	-	2	0



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 31 өдөр

Дугаар 01/ХА-2024/03/МА-СТА-ТТЗ.
139 А 1170308

Чойбалсан хот

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Цагаан-Овоо сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хоршоо хөгжүүлэх сангаас олгосон зээл, зээлийн хүүгийн 68.1 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн авлагын үлдэгдэлтэй байна. Авлагыг барагдуулахаар шүүхийн байгууллагуудаар шийдвэрлүүлсэн 18 иргэний 41.7 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн авлагын үлдэгдэл өмнөх оноос буураагүй, 2023 онд зээлийн хугацаа хэтэрсэн 8 иргэний 26.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалаар батлагдсан "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 3.4.5 дахь "зээл зээлийн хүүгийн орлогыг сангийн дансанд төвлөрүүлэх", 3.4.11 дэх "сангаас олгосон зээлийн эргэн төлөлтийн төлбөрийг зээлдэгч төлөхгүй тохиолдолд сумын Засаг дарга уг төлбөрийг төлүүлэх арга хэмжээг авч зээлийн дансанд төвлөрүүлнэ" гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.8-т "байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй", 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шүүхээр шийдвэрлүүлсэн авлагыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт шилжүүлэх, бусад хугацаа хэтэрсэн авлагыг барагдуулах ажлыг удирдан зохион байгуулах, биелэлтийг 2024 оны 11 дүгээр сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цагаан-Овоо сумын Засаг дарга Д.Батмагнай, Санхүү албаны дарга С.Гэрэлмаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Шүмэг И.СЭМЖИДМАА

АУДИТОР

Б.ОДХҮҮ



011041271



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 31 өдөр

Дугаар 00/2024/03/МА-СТА-ТТБ
190 1170308

Чойбалсан хот

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Цагаан-Овоо сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд ОНХС-гийн хөрөнгөөр нийт 1418.9 сая төгрөгийн 27 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 55.0 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээ огт хэрэгжээгүй, 72.0 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээ 50.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2-т "Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ", 41.2.7-д "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.8-д "байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй", 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төлөвлөсөн төсөл, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх, гүйцэтгэлд хяналт тавьж, хүрэх үр дүнг хангаж ажиллах, биелэлтийг 2024 оны 11 дүгээр сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цагаан-Овоо сумын Засаг дарга Д.Батмагнай, Санхүү албаны дарга С.Гэрэлмаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

АУДИТОР

И.СЭМЖИДМАА

Б.ОДХҮҮ



011041274

